

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрэндорж	Дугаар	L098
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Жаргалтхаан
Төрсөн газар	Жаргалтхаан сум	Төрсөн он	1926
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Пунцогтэгчинлэн буюу Баатарын дацан, Гичгэний хурал, Уугийн хурал, Мэргэн хамбын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 010, ХЭЖХ 011, ХЭЖХ 014, ХЭЖХ 015
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Пунцогтэгчинлэн буюу Баатарын дацан, Гичгэний хурал, Уугийн хурал,
Мэргэн хамбын хийд

Хүрээнээс явж байгаа лам уу?

-Тийм, хүрээний лам байна. Би нэг судалгааны ажилтай явж байна даа

Хаанаас, хаана байдаг лам вэ?

-Гандангаас

Хотод байдаг лам уу?

-Тийм, хотод байдаг. 1937 оноос өмнө монгол нутагт байсан сүм хийдүүдийг судлах зорилготой явж байна.

1990 оноос шинээр сэргээн байгуулагдсан мөн хуучин 37 оноос өмнө байсан хийдүүдийг судлахаар явж байгаа. Монгол нутаг даяар 6 баг гарч ажиллаж байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай энэ хавиар олон хийд байсан юм байна лээ. Тэр баруун хойд ууланд Уугийн хурал гэж байсан юм билээ. Дэмчиг тойны Шиврийн шүтээн гэж байсан. Дэмчиг тойн гэдэг чинь сүүлд лам болсон юм байна лээ. Хутагт хүн байсан. Энэ Мэргэнийхээс тасарч тэнд очиж отог байгуулаад Тойны отог гэж отогтой болсон.

-Баянзүрх уулын өвөрт байдаг уу?

Тийм.

-Улаан худгийн энд нэг юм байсан уу?

Улаан худгийнх ч дээр байхгүй болсон л доо. Хойно Хамбын хийд байна. Тэр нь чинь одоо саяхан болтол туурь нь байж байсан. Тэгээд Тахилтын хийд бас Гичгэний хийд гэж байсан. Тэгээд Хутагтын хүрээ байсан.

-Уртын шүтээн гэж бас байсан байна?

Уртын шүтээн гэдэг чинь Мэргэн хамбын хийд чинь. Мэргэн хамба гэдэг чинь түүхийн хувьд том хүн байсан юм байна лээ. Богдын 7 хутагтын нэг гэнэ лээ. Манай нутгийн лам байсан.

Энэ Баатарын дацанд намайг бага байхад Майдар эргэдэг байсан. Майдар эргэдэг байгаад тэр хойно очиж үдэлдэг байсан. Хайлан хурдаг байсан.

-Баатарын дацан, Пунцагтэгчинлэн хийд хэдэн онд байгуулагдсан юм бол?

Он нь дээр байх аа.

-Би 1918 онд байгуулагдсан гэж дууллаа. Та бол 1927 оны хүн, манай ажаа 1928 оны хүн дээ? (Санжаажав лам-Жаргалтхаан сум)

Тэгж ярихгүй. 1927 он гэж ярихгүй, 1918 он ч гэж ярихгүй. Их дээр байх.

-Та тэр үнзад Гэндэн гэдэг хүнийг таних уу?

Мэдэхгүй намайг байхад байхгүй байсан.

-Өндөр Цэнджав хүн гэж үнзад хүн байсан уу?

Байсан. Тийм ээ тийм. Нэг тааруухан үнзад байсан юм. Тэр Гэндэнтэй садан байсан. Гэндэн гэдэг хүн чинь айхтар лам байсан болтой.

-Тэр Гэндэн чинь анх бий болгосон юм уу?

Үгүй байх аа.

-Бизъяа гуай тэгж ярьж байх юм. Гэндэн гэдэг үнзад бий болгосон. Тэгээд 1918 онд байгуулагдсан надтай чацуу гэж ярьдаг байсан юм. Тэгэхдээ би сайн мэдэхгүй байна.

Сүүлд нь сүүлд л байх. Гэхдээ арай 1918 он нь юу юм. Байгуулахын тухайд би өөрийн дуулснаа хэлэхэд нь бүр улс ууланд гарч дуганы модоо хийж байсан гэж байгаа. Дуганын багана мод. Тэгээд хурал ном, Найман гэгээн уншаад тахил махилаа өргөөд маргааш нь авахад шал өөр болчихоод байдаг байсан гэж. Тэгээд аваад үхрээр зөөж байсан гэсэн. Энд барьдаг нь Хүрээг дууриалгаж байгаа ухаантай. Тэгсэн гэж манай багш айлдаж байсан.

-Хүрээний дөрвөн дацанг дууриалгаж уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хүрээний дөрвөн уулыг. Баруунтайгаа нэг уултай, баруун хойноо нэг уултай, зүүн хойноо нэг уултай, урдаа нэг уултай. Тэрийг нь дуурайлгаж энд байгуулсан юм гэж хэлж байсан. Энд байгуулна тэнд байгуулна гэж байсан болтой юм байна лээ.

-Хүрээ дэгтэй байсан уу?

Хүрээний уулнуудыг түшүүлж тэр урдхыг чинь Жанцант гэдэг юм.

-Тэгэхээр дуганы хэмжээг төсөөлөхөд хэр зэрэг том байсан бол? Би сая хэмжээд үзэхэд ер нь 20х30 хэмжээтэй дуганууд байх шиг?

Аа бий байх, тийм байх. Их том дугантай байсан даг.

-Голбогийнхны дуган байсан юм уу?

Голбогийн дуган чинь хамгийн том нь. Зүүн урдаа байгаа. Тэр жилийн суварганы зүүн урд нь байгаа.

-Суваргыг Голбогийн дацангийн суурин дээр барьсан гэсэн. (Санжаажав лам-Жаргалтхаан сүм)

Суурин дээр нь үү?

-Тийм суурин дээр нь гэж Ажаа хэлсэн. (Санжаажав лам-Жаргалтхаан сүм)

Би одоо бага байсан болоод...

-Баруун урагшаадуу харсан ийм дацан байсан байна тийм үү?

Тийм байх. Тэр баруун урд нь нэг хонхорхой байсан.Тэнд нь худаг байдаг байсан юм.

-Тэр үед Баатарын дацангийн лам нар хэр олон лам нар хүрж байсан вэ? Дандаа нутгийн лам нар байсан уу?

Аль эсвэл хүрээнээс лам нар залж ирж байсан үү?

Үгүй, өөрөө ерөөсөө байнгын хуралтай 4 газар байсан юм. Суварга гэж байсан.Голбог гэж байсан.Өрлүүд гэж байсан. Тайж нар гэж байсан. Дөрвөн хэсэг хурна. Голдоо Батцагаан нэртэй Ганжуурын дугантай байсан. Хайлан хүрж байсан.Би нэг хайлан хурахад нь ах ламындаа байж байсан. Ганцаараа үлдчихээд хуралдаа яваад ирэхэд нь хашаа байшиндаа ганцаараа л байлаа. Манайх том хашаатай айл байсан. Хүрээнийх шиг өндөр шургааган хашаатай байсан юм.

-Сахиусаа хэдэнд хүрж байсан бэ? Ямар улиралд хурдаг байсан юм бэ?

Сахиус намар Хангал гэж хүрж байсан байсан.

-29-нд хүрж байсан уу?

Хүрж байсан. Хангал их хурна.Зарим шөнө нойргүй хононо.Хангалын хүнс гээд чихэртэй ааруул бие биендээ өгөөд нэг нойргүй хонож л байсан.

-Баатарын дацанг ямар хүний санаачлагаар хошуу ноён, хутагт хувилгаад хэний байгуулсан юм бол?

Хошуу ноёных байх. Энэ чинь одоо хуучнаар Цэцэн хан аймаг Баатар бэйлийн хошуу, тэгээд Баатар бэйлийн дацан гэж нэрлэсэн юм

-Баатар бэйлийн хошууны нь Тамгын газар нь хаана байсан юм вэ? Одоо хийдээсээ хаана байсан вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хошуу нь уу? Тусгай газар байдаггүй, ердөө тэгээд нүүгээд байдаг байсан гэсэн. Бөхийн нуруунд нэг жаахан өвөлжөө байдаг. Тэнд байсан. Сүүлд ардын засаг мандаад өөр болсон. Баатар бэйл гэдгийг нь байлгаад Баянзүрхийн хошуу гэдэг болж Дээд Цэнхэр ч Чандманын тэнд суурьшсан. Тэгээд манай ах дарга нь байсан ш тээ. Чандманын өвөрт 1930 хэдэн оны үед байсан.

Ардын засаг мандаад ноёны нэрээр байлгахгүй гэж тараагаад манайхан тарахгүй гээд манай Даш гуай бичээчээр очсон гэдэг юм. Сайн бичээч байсан юм. Манай Батцэрэнгийн эцэг энэ тэр чинь.

-Та Баатарын дацанд шавилж сууж байсан уу?

Үгүй, би нэг жаахан ламархуу ухаантай хүүхэд байсан. Манай нэг ах лам байдаг байсан юм.

-Танай ах Баатарын хийдийн ямар хэргэмтэй хүн байсан вэ?

Тэр яахав. Зүгээр номтой л хүн байсан. Гэсгүй байсныг нь би мэддэг юм. Сүүлд нь баригдаад алуулсан.

-Та Баатарын дацанд шавилан сууж байхдаа хэдэн настай байсан вэ?

7,8 настай байсан. 11,12 настай байхад байхгүй болсон. Би үргэлж сууж байгаагүй. Ах лам дээрээ хааяа нэг очдог байсан.

-Байгуулагдсан он нь сонирхолтой юм. Баатар бэйл гэж хэдэн оны хүн бэ? 1800-гаад оны хүн үү?

Тийм. 1800-гаад оны хүн

-Тэр үед л тэр хүний санаачлагаар байгуулсан юм уу?

Тийм байх. 2 ноён байсан. Сан бэйл ноён гэж байсан. Тэр хүн л байгуулсан байх даа. Тэр хүн чинь дээгүүр ноён байсан юм. Их дээгүүр хүн байсан гэдэг. Тэр хүний тухай их хачин хачин юм ярьдаг юм. Одоо богд гэгээн тугдам барьсан. Ёсолсон. Тэгэхэд Манай эндээс Сандаг хамба гэдэг лам байсан гэх юм билээ. Тэр ламаар аравнайлуулж гэрээ. Баатар бэйл, Сан бэйл гэдгээр тооноо бариулсан юм гэнэ лээ. Тэгээд хаадууд их дургүйцэж зүгээр нэг хошууны ноён хүн гэж

-Сандаг хамба гэдэг хүнийг байх үед энэ хурлыг бий болгосон. Сандаг хамбыг байх үед хүрээнд суудаг манай нутгийн гавж гэвш нар ирээд хурдаг байсан юм гэнэ лэ. Тэр үед чойртой болгох гэтэл Сандаг хамба чойртой болгоогүй юм гэж манай ажаа хэлж байсан. Сан бэйл гэдэг хүнийг байх үеийн хүн юм уу да. Тэр хүн хамгийн эхний хошуу ноён хүн юм уу? (Санжаажав лам-Жаргалтхаан сүм)

Сан бэйл гэдэг чинь залгаж байсан хүн байх.

Сан бэйл гэдэг хүн бурхан болоод. Их том ноён байсан юм. Богдод их таалалтай хүн байсан гэдэг. Ан их хийдэг, архи их уудаг, шударга, бусдад их тусладаг хүн байсан гэдэг. Хэнийд ч хамаагүй очдог, ядуу зүдүү гэлтгүй хамаг юмаа тайлаад өгдөг, ёстой нэг шударга хүн байсан гэдэг.

-Очирпүрэв гуай хэдэн настайдаа таалал болсон вэ? (Санжаажав лам-Жаргалтхаан сүм)

Очирпүрэв чинь үхэртэй хүн байсан юм. Одоо байсан бол 95 настай хүн байх байсан. Сан бэйлийг байх үед арван хэдтэй л хүүхэд байсан юм байна. Сан бэйл ноён хөдөө архи уугаад айлд сууж байсан. Айлын хүн ноён ахыгаа хараад ир гэхээр ноён ахын дэргэд зөч сууж байна гэж хэлж байсан гэж байгаа. Очирпүрэв гэдэг далдыг хардаг номтой хүн байсан. Тэгэхлээр 1920-иод он болох уу? Арван хэдэн он уу? Арай ч эрт юм шиг л байгаа юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай багш чинь одоо жаахан хүүхэд ирж сууж байсан гэж ярьдаг юм шүү дээ. Манай багш чинь 1900 онд төрсөн хүн шүү дээ. Баянд ээжтэйгээ амьдарч байгаад нэг өдөр үхэр тэрэгтэйгээ дацанд ирж байсан. Ээж нь айлд орхичихоод яваад өгсөн. Дацангийн ойролцоо эмэгтэй хүн хонодоггүй. Тэгээд ном заалгаад байсан. Аргал түлдэг, ил галтай. Заримдаа аргал нь ноцдоггүй утаа баагидаг байсан гэсэн. Тэгж нэг хагас жил суусан. Хойтон жил нь мөн л өнөөх ламтайгаа цуг байсан. Тэгсэн чинь номын багш нь үхчихэж гэнэ. Хариугүй гэнэ. Айгаад хүрч чаддаггүй гэнэ. Тэр үеийн түүхээ манай багш их сайхан ярьдаг байсан юм.

-Түхайн үед шавилан сууж байсан лам нарын тоо хэд байсан вэ, нийтдээ?

100 лав гарах байх аа. Зарим нь хүрээнд суучихдаг. Хүрээнийхэн зун ирж хураад намар яваад өгдөг байсан. Үндсэн хэдэн лам нар нь үлддэг байсан.

-Доржпүрэв гуайн ах лам гэж ямар хүн байсан юм вэ? Богдоос хамбад өргөмжлөгдсөн хүн байсан?

Шарав гэвш гэдэг хүн байсан гэдэг юм.

-Хүрээний Дашчоймбол дацангаас ирж хурдаг байсан үү?

Дашчоймбол үгүй, Намдолин аймгийнхан энд хурдаг байсан. Намдолин аймгийнхан хурж байх үед хамба нь гэл үү? Гэсгүй нь гэл үү? Энд нэг хүн ирж хамба болсон юм гэсэн. Жамъян аграмба гэдэг хүн байсан гэнэ. Энэ хурлыг эхэлж буй болгосон гэсэн.

Манайхан чинь бүгдээрээ Намдолинд хурдаг байсан юм. Жамъян аграмба гэдэг хүн энэ хийдийг бий болгосон гэсэн. Дараа нь Дорж аграмба гэж болсон. Бараг ижилгүй шахуу хүн байсан юм гэнэ лээ. Болд захирагчийн хүү. Болд захирагч гэж их цэцэн хүн байсан юм гэнэ лээ. Манай хошууны хүн байсан гэсэн. Цэцэн Болд цолтой 1800 оны сүүл үед байсан хүн. Жамъян аграмба гэдгийг чинь бурхан болоод давслаад, алтдаад тэгээд залсан. Тэрний дараа Дорж аграмба гэж гарсан. Дорж аграмбыг суугаагаараа таалал болсон гэдэг юм. Гэнэт налчихсан. Тэгээд 49 хонуулсан юм гэнэ лээ. Тэгээд сүүлдээ тэгширчихээд байсан гэдэг. Тэрийг нь далимдуулаад үнэр оруулчихсан байсан гэдэг үг байдаг юм. Дорж аграмба манай хошууны цэцэн Болд гэдэг хүний хүү. Мундаг түшмэл байсан гэдэг. Тэгэхээр 1800 оны сүүл үе гэж л ярих байх. Тэр Намдолин аймгаас л ирж бий болгосон байх. Жамьяа-Аграмба гэдэг хүн ирж энэ хийдийг бий болгосон юм гэнэ лээ. Хамба нь байсан юм гэнэ лээ.

Сүүлд тэр Сандаг хамба гэдэг чинь мундаг хүн байсан гэнэ лэ. Манай нутгийн хүн байсан юм.

-Та Уугийн хийдэд очиж хурж байсан үү? очиж байсан үү?

Үгүй, Уугийн хийдийнхэн манай энд ирж хурж байсан юм гэнэ лээ. Бүгд ирнэ л дээ.

-Тойн ламын хийдээс ирж хурж байсан үү?

Тойн лам ирж хурдаг байсан юм гэнэ лээ. Уншлага энэ тэр хийхгүй. Тэгээд л гараад гүйчихдэг тийм хүн байсан юм гэсэн. Манай ах тэгж байсан. Тойн лам гэж хачин хүн байсан юм гэж.

-Хуучин баатар бэйлийн хошууны бусад дацан хийдүүдээс таныг байхад энд ирж хурж байсан үү? Тахилтын хийдээс ч юм үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тахилт махилтаас намайг байж байхад ирж байгаагүй шахуу байх аа. Энэ Гичгэнэ чинь л манайхаас тасарсан юм гэнэ лээ дээ.

-Тэгэхээр Гичгэнэ арай сүүлд байх нь үү?

Сүүлд байх.

-1918,1919 оны үед үү?

Тийм байлгүй дээ.

-Ер нь хүрээ дэгтэй газар байсан юм уу?

Тийм. Одоо хийдийн хэрэглэж байсан юмны хувьд бол тэр үед чинь хүн юу байдгийгаа хайрлахгүй өгч байсан юм шүү дээ.

-Баатарын дацанг хэдэн онд хаах тушаал өгч байсан юм бол?

1937 онд хаасан.

-Шууд л хаасан уу?

1937 он гараад л. 1937 оны өвөл барьсан. Тэрийг нь би мэдэж байна. Анхан лам нарт чинь маш татвар оногдуулж байсан юм. Лам нар татвараа дийлэхгүй. Тэгээд лам нарыг өвлөөс эхлээд барьж эхэлсэн юм. 1937 оны өвлөөс эхлээд хамгийн түрүүнд Банзрагч гавж гуай, Жамъян ноён баригдсан юм даа.

-Сан бэйлийн дараа Жамъян ноён гэдэг хүн байсан үү?

Жамъян ноён гэдэг нь Сан бэйлийн дүү нь байсан юм. Ноёны наадам гэдгийг хийж байсан гэдэг юм.

-Та энэ хийдийг хаагдтал байсан уу?

Үгүй, 1937 оны намар манайд нэг хар хүн байсан юм. Гомбо даргын аав.Тэгээд энэ одоо хэрэггүй гээд. Мэддэг хүн байсан юм.Тэгээд би 1937 оны өвөл хөдөө хонь хариулаад өвөлжиж байсан юм. Тэгээд л өвөл нь цагаан сараас хойш бариа тавиа эхэлсэн.

Баатарын дацангийнхан чинь Баянцогтыг тахина. Бусад энэ тойрсон уулнуудаас ямар ямар уул овоог тахиx вэ?

Баянцогтыг тахина. Энэ баруунтай Бумбат гэж тахина. Хүүхэн овоо, Бүрдэн дэнжийг тахина. Хойно Өлзийтийг тахидаг байсан. Өлзийтийг чинь Хүрээнээс Намдолин аймаг ирж тахиж байсан юм гэнэ лээ.

-Баатарын дацанд хамгийн ойрхон хийд нь Уугийн хийд болж таарч байна уу? Гичгэнэ үү?

Гичгэнэ, Уу хоёр ч хана байх аа. Сайн мэдэхгүй байна.

-Өөр ойролцоо жижиг хурлууд байна уу?

Уугийн хийд гэж байсан. Зүүн хойно нь Баянзүрхийн өвөрт Тойны отог гэж байсан. Хамбын хийд, Уртын шүтээн гэдэг чинь нэг юм.

1937 оны цагаан сараас л лам нарыг нь бариад эхлэсэн юм аа даа. Хамаг юмыг нь шатаагаад тэр юуны чинь хэрэгсэлд учиргүй их мөнгө байсан юм. Тэрийг чинь тэмээн тэргэнд ачаад аваад явж байсан гэдэг юм. Толгой Цэндсүрэн гэдэг чинь муухай амьтан байсан юм. Тэр чинь 2, 3 тэмээн тэргээр аваад явсан гэдэг юм. Тэгээд нөгөө шар цоохор, хүрэн цоохор олбогнуудыг бүгдийг тэгээд ачаад явсан. Тэгээд одоо энүүгээр яваад зүүн Хар нуурт буучихсан гэдэг. Хойд зүгийнхийг бүгдийг нь ачаад. Одоо ярихад худлаа л гэнэ дээ. Тэгээд нөгөө том том

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

авдранд хийгээд мөнгө гэдэг чинь замгүй хүнд юм, тэгээд үхэр тэрэг, тэмээн тэргээр аймаг очиж гэнэ. Хэлтсийн хашаа гэдэг юм байсан юм. Авах хүн байдаггүй гэнэ. Тэгээд зүгээр хашаан дотор нь буулгачихаж байсан гэдэг. Ярих юм биш. Бусдыг нь би яаж мэдэх вэ дээ. Манай Голбог гэдэг чинь олон ламтай байсан. Хамгийн сүүлд Голбог л хамгийн олон ламтай байсан даа.

- Хэдэн ламтай байсан бэ?

Мэдэхгүй. Энэ хийдээс, Баатарын дацангаас миний мэдэхийн 30 гаран хүн байхгүй болсон байна лээ. Иргэж ирсэн хүн бүдүүн Цэнд, Лувсанцэрэн гуай хоёр л байна даа. Манай нэг ах, Зүндүй гэдэг ирсэн юм аа.

-Б. Ринчен гуайн судалгаан дээр Уулын хийд гэж байгаа нь Уугийн хийд юм байна?

Тийм. Уртын шүтээн гэдэг чинь Мэргэн хамбын хийд. Тахилтын шүтээн гэж байгаа. Зүүн хойно бий.

-Пунцагдагдалин хийд, Цэнхэрийн гол гэж байна?

Энэ Баатарын дацанг хэлж байна.

-Тойны отгын хурал гэж байна?

Баянзүрх уулын тэнд. Цагаан суварга гэж байсан юм.

-Хаана байсан юм бэ?

Тэр чинь бүр энэ Баянголын ард байсан юм

-Ямар учиртай газар байсан юм вэ? Зүгээр суварга байсан юм уу?

Мөрөн голын цээжинд байгаа суварга. Зүгээр л суварга байсан. Мөргөнө гээд л явдаг байсан.

-Өөр Жаргалтхааны нутагт байсан хийдүүдээс энд ороогүй ямар хийд байна?

Гичгэнэ ороогүй байна. Тэмдэглэхгүй бол болохгүй.

-Гичгэний хурлыг мэдэх хүн хэн байна?

Мэдэхгүй. Одоо хэн байхав. Зүгээр хурал байсан газар нь нэг суварга босгочихсон байгаа.

-Гичгэний хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан юм бол ?

Мэдэхгүй.

-Энэ хийдүүдийн төвд нэрийг мэдэж байна уу?

Мэдэхгүй. Хутагтын хүрээ манайд орохгүй байна уу?

-Өмнөдэлгэрт орж байна. Тойны отгийн хурал, Шиврын хурал гэдэг чинь нэг газар юм байна?

Тийм.

-Энэ судалгаанд тэмдэглэгдээгүй таны мэдэх санаанд бууж байгаа Жаргалтхаанд харьяалагдах хуучин сүм хийдүүд байна уу?

Мэдэхгүй.

-Жамьян аграмба, Дорж аграмбаас өөр зохиол бүтээл туурвиж байсан хүн байсан уу?

Байсан байлгүй дээ.

-Хувилгаан хүн байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нэг хувилгаан нэртэй лам байсан. Тайжийн Дамдин гэлэн гэдэг лам байсан. Энд бас манайхны хамаатны хувилгаан хүн байсан. Чой гэлэн гэж айхавтар чадалтай хүн Гичгэнд байсан. Тэр айхтар чадалтай хүн байсан гэсэн.

-Тэднээс уул овооныхоо тахилгын судрыг зохиосон гэдэг юм уу? Дацангийнхаа солдивыг ч байдаг юм уу?

Мэдэхгүй юм аа. Өрлүүд гэдэг л энэ суваргыг тахидаг байсан юм. Энэ Байцыг чинь Голбог тахиж байсан байх.

-Баатарын дацангийн гол сахиус нь ямар сахиус байсан юм бол? Ядамладаг бурхан нь?

Таван хаан байсан. Голбог таван хаантай.

-Дөрвөн отог өөр өөр байсан уу?

Тийм. Суварга чинь одоо юутай байсан юм бол доо? Өрлүүд Гомбо. Тайж нар Таван хаантай байсан байх.

-Тайж, Голбог хоёр ижил сахиустай байсан юм уу?

Тайж нар Лхам байх аа. Суварга одоо ямар сахиустай байсан юм бол доо?

-Дацангийн гол шүтээн гэж байсан уу?

Байлгүй яахав. Гол гэдэг чинь Ганжуураа хэлнэ биз дээ. Намайг байж байхад л хоёр аграмба байдаг байсан. Банзрагч аграмба гуай, Нуваанбалдан аграмба гуай гээд.

-Дугаржав цорж гэдэг чинь ямар хүн байсан юм бэ?

Аа тэр их том. Хүрээний дөрвийн нэг шүү дээ. Бас аваачаад л үгүй хийчихсэн юм даа. Энд хөдөөлдөг байсан юм. Одоо нүд чинь юу ч харахаа байчихаад байна аа.

-Та дөрвөн дацангийнхаа хамба лам цорж унзадын нэрийг мэдэх үү?

Суварганых манай багш гэсгүй нь байсан юм билээ дээ. Манай багш Буриад гэлэн гэдэг хүн. Монгол бичиг гаргах уу?

-Гаргана аа.

Энд баригдсан улсуудыг нэрийг бичсэн юм даа.

-Бизъяа гэж байна.

Бизъяа гэдэг чинь хүрээний том гавж. Ганжуур манжуурыг чинь цээжээр явж байсан гэдэг. Манай нутгийн хүн байсан. Хөдөөлж ирдэг байсан. Банзрагч аграмба, Нуваанбалдан аграмба, Дугаржав цорж, Бэгзжав, Лувсаншарав гавж, Дэндэв гавж, Тайжийн Дамдин, Нямдаш гэлэн, Цэнд гавж, Зундуй гэлэн, Сандаг гэлэн, Дагва гэлэн, Цэнддорж гэсэн хүмүүсийн зарим нь манай нутгийн хийдэд сууж байгаагүй боловч ирдэг очдог хөдөөлдөг манай нутгийн хүмүүс байсан. Хонь хариулж байсан хүнийг тоо нь гүйцэхгүй байна гээд бариад явж байсан гэдэг. Нүгэлтэй тэнэг ажил шүү.

- Анх хийдээ барихдаа 4 отгоо барьсан юм уу? Дөрвөн отог нь сүүлд бий болсон юм уу?

Ёстой мэдэхгүй юм аа. Сүүлд нь бий болсон байлгүй дээ. Отгууд тус тусдаа сахиустай, тус тусдаа ламтай, гэсгүйтэй байсан.

- Дацангийн түүхэн гар бичмэл гэж байдаггүй юм байх даа?

Устгачихаа биз дээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэн нэгэн хүн аваад үлдчихээгүй байдаг юм байх даа?

Үлдэх хүн гэж олигтой юм байхгүй. Ёндон гэдэг ядуу лам байгаад тэр чинь одоо балласан шүү дээ. Хурал номных нь юмыг аваачаад булчихсан. Сүүлд нь олоогүй шүү дээ.

- Та хүрээнийхээ ерөнхий байршлын зургийг нь зураад өгч чадах уу?

- За хө баруун талд нь Суварга гээд байгаа. Өрлүүд нь баруун хойно, зүүн хойноо Тайж нар, Голбог нь Суварганы ханатай зүүнтэй байсан. Голд нь гол дацан хийд нь байх юм даа. Ганжуурын дугана, Батцагаан дуган голд нь байсан. Сайхан өндөр шаттай, зуны хурал хурдаг сүмтэй дуган байсан.

-Суврагнууд нь хаана байсан бэ?

Суварганууд нь дөрвөн талдаа байсан. Хамба лам нь сүүлийн баригдахын үед Нуваанбалдан аграмба байсан юм байна лээ.

-Аль дацангийн хамба байсан юм бэ?

Ерөнхий хийдийн хамба байсан юм. Шагдарсүрэн гэдэг хүн Намдолин аймагт лам байсан хүн ирээд хэлсэн гэнэ. Нэг монди байсан юм. Нуваанбалдан аграмба Намдолин аймагт хамба байсан. Шагдарсүрэн үнзад нь байсан. Тэгээд хувьсгалч болоод хамбыгаа барьсан гэж байгаа. Муухай хүн шүү.

- Хүрээний лам нарын байр хаана байсан вэ?

Баруун хойноо нэг хэсэг нь байсан юм. Зүүн талаараа бас байсан. Баруун урдаа бас нэг хэсэг нь байсан юм. Суварга гэдгийн урд. Яахав дээ. Зарим нь тэгээд нэг хашаа байшинтай, даржин даа даржин.

-Баатарын дацанд ном барладаг байсан уу?

Мэдэхгүй ээ, бичдэг л улс байсан.

- Танд Уугийн хийдийн талаар өөр ярих зүйл байна уу?

Уугийн хийдийн тухай ярих юм надад байхгүй юм аа. Сүүлд нь миний үеийн нэг хүн байсан. Лам хүн байсан. Тэр л хаалгыг нь хаагаад зул өргөж байгаад үлдсэн гэж байсан. Уугийн хийдийн тухай Дэндэв гуай л сайн мэднэ.

-Сарын дүйчэнгүүд бүгд хурдаг байсан уу?

Тийм байх

-Шинийн 8,10, 15, 29 гээд л

Аа тийм. Тогтмол хурна.

-15-ны Чойнпрүл жона, Цэдэр Лхам хурдаг байсан уу?

Цэдэр Лхам хурахад Баяны энгэрээс Уугийн хурлаас явган ирж ном уншдаг байсан гэж байгаа. Тэгээд Цэдэр Лхамдаа хурчихаад өглөө нь яваад өгдөг байсан гэсэн. Галсандампил гэдэг хүн их явган явдаг байсан гэсэн.

-Хуучин хурал хүрж байсан уу?

Хуралгүй яахав. Хангал чинь харин намар 3, 4 өдөр хурдаг байсан. Хүрээний Хангал чинь өвөл хүрж байсан шүү дээ.

-Тус тусдаа намар хүрж байсан уу?

Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хайлангаа хэзээ хурдаг байсан вэ?

Одоогийн зуны дунд сард хурдаг байсан байх. Зулын 25-ны мундаг хурал болно. Тос бариад л мундаг хурдаг байсан.

-Майдар хэдүйд эргэдэг байсан бэ?

Майдар зуны эхэн сард эргэж байсан шиг санагдах юм.Майдарт хоёр л эргэж үзсэн юм байна аа даа. Нэг тэрэг түрээд л явж байсан. Би бага байсан.

-Майдарыг жилд хэд эргэдэг байсан бол?

Нэг л эргэдэг байсныг нь би мэдэх юм байна.

Цам гардаггүй байсан гэсэн үү?

Цам гардаггүй байсан.

-Ганжуур эргэж байсан уу?

Эргэж байсан юм гэнэ лээ. Бүр нутгаа тойроод эргэж байсан юм гэсэн.

Хошууныхаа хилийн дээсээр эргэж байсан уу?

Тийм. Энэ чинь овоотой юм билээ ш тээ.

-Хэр олон лам нар оролцож явж байсан юм бол?

3, 4 хүн явалгүй яахав.

-Нүгнээ сахидаг байсан уу?

Сахидаг байсан. Бүтэн өдөр дуугүй байдаг байсан шүү дээ.

-Хийдийн маань байгууламж ямар материалаар хийгдсэн байсан бэ?

Модон дуганууд байсан. Нэг чулуун ханатай жаахан дуган байсан шиг санагдаад байгаа юм. Голбог чинь хоёр дугантай байсан.

-Голбогийн хийдийн баруун талд суварга байгаагүй юу?

Ер нь дотор тийм юм байхыг мэдэхгүй байна. Мэдэхгүй дээ. Мартчихгүй яахав.

-Сүмийн хэлбэр нь ямархуу хэлбэртэй байсан бэ?

Цэндсүрэн, Жамъян бид гурав нийлбэл жаахан гайгүй байх. Би сайн санахгүй байна.

-Баатарын дацангийн эргэн тойрны уул, газрын нэр нь ямар ямар нэртэй вэ?

Урдаа Таван гэдэг уул. Жанцант уултай. Баруун урдаа Баянцогт, хойд талдаа,Өвгөн овоо, Бүмбат гэдэг овоотой, зүүн талдаа Нүүрэнтий гэдэг уул байдаг. Баян хаан, Баян-Уул, Цэнхэрийн Бүрд, Өлзийт, Эрдэнэ, Тахилгатыг, Хар модотыг манай хошуу тахидаг байсан.

-Уулын тахилгын судар нь юу байсан вэ?

Тэр одоо байхгүй болсон олдохгүй юм билээ. Мэдэхгүй

-Хийдийг хаагдах тушаалыг ямар хүн өгсөн бэ?

Мэдэхгүй. Тэр үед нь нэг айхтар хүн л хийж байгаа юм аа.

-Хийдээ хаагаад л нураасан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэгсэн байлгүй дээ.

-Дуганын барилгыг яасан бэ?

Хойд суман дээр аваачсан. Хоршооны байшин, түүхий эдийн байшин, барааны склад гээд л барьсан даа.

-Хийдийн судар номноос авч үлдсэн юм байгаа юу?

Байхгүй байх аа. Харин ганц Ганжуурын шүүгээ бий. Тэр яаж үлдсэн юм.

-Сүм хийдийг хаагдах үед ямар үйл явдал тохиолдож байсан бэ?

Настай лам нарыг нь барьж аваад, хийдийг нь нураагаад, юм хүмийг нь шатаахыг нь шатаагаад тэгээд л нураагаад л. Үлдсэн лам ухаантай ганц нэг улс байсан юм. Тэр хүмүүс ганц нэг юм нуугаад газар булчихсан. Тэгээд дараа нь олдоггүй юм. Ёндон гэж нэг хүн байсан. Тэр Улаан юм энэ тэрийг нь нуугаад булсан. Дараа нь олоогүй.

-Баатарын дацан шарын шашны урсгал байсан биз дээ?

Тийм ээ, Шарын шашных. Уугийн тэнд том лам байсан гэдэг бид нар шавь орж байсан

-Та хэдэн настай сахил хүртэж байсан вэ?

5, 6 настай байсан.

-Сахил хүртэхээд хийд дээр сууж байсан уу?

Үгүй ээ. Тэр ламыг хүрээний цорж багш гэдэг байсан юм. Мундаг багш байсан юм. Одоо энэ Согоотод заларч байсан юм гэнэ лээ. Цэнхэрмандалын хүн байсан юм гэнэ лээ. Тэгээд Ганжуурын лүн тавьсан юм. Манайхны энэ хавийхан бүгдээрээ очсон. Манай лам нар, манай багш. Очиж юу гэнэ үү хийж байсан. 1931, 32 оны үед л юм. Нэг гурван юм лам болох гээд мөргөж ч мэдэхгүй, очиж байсан гэдэг. Тэгж явж байсан хүмүүсээс би ганцаараа үлдээд байна.

-Тэр хамт явж сахил хүртэж байсан хүн чинь хэн хэн байсан юм бэ?

Нэг нь Гомбо гэдэг байсан юм. Нөгөөдөх нь Гомбожав гэж хүн байсан

-Дацангийн мяндагтан лам нарын талаар та мэдэх үү? Таны мэдэж байгааг тэмдэглээд авья?

Одоо энэ нийт хийдийн хамба лам бол Нуваанбалдан аграмба байсан. Тэгээд гэсгүй нь одоо тэр үед өөр нэг хүн болоод байсан байхаа. Өнөөх лам нарыгаа үймээд ирэхдээр зэрэг зүгээр жижиг улсаар гэсгүй гэж тавьж байсан. Дамдинжав гэж нэг ядуу лам байсан.Тэрийг л тавьсан болов уу. Нөгөөдүүлийг нь тус тусд нь хэлбэл хэлэх л юм.

-Нөгөөдүүлийг нь тус тусд нь хэлбэл сайн байна?

Тэгвэл баруун Суварганых Дэндэв гэж хүн хамба нь байсан. Гэсгүй нь Лувсанцэрэн.

-Цорж лам нь?

Тэднүүдийг нь би мэдэхгүй байна.

Ундзад нь?

Унзадыг нь бас мэдэхгүй. Хойдох Өрлүүд гэдгийг нь Цэвээн гэлэн гэдэг нь хамба лам нь байсан байх. Унзад нь Лувсангомбо гэж хүн байсан. Гэсгүй нь Даш гэлэн гэдэг хүн байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Ловон лам?

Ловон лам гэж байгаагүй. Харин да лам гэж байсан.

-Да лам нь хэн гэдэг хүн байсан юм бол?

Да ламыг нь би мэдэхгүй. За Тайж нарых чинь хамба нь хэн билээ? Дамдин гэлэн гэж байсан. Унзад нь Монхоон Цэнд гэж байсан.

-Гэсгүй нь хэн байсан бэ?

Цэнд гавж гэдэг хүн гэсгүй нь байсан юм билээ. Голбогийнх чинь хамба нь Иш гэлэн гэж байсан байхаа. Унзад нь лам Гомбо гэж байсан. Нямдаваа гэдэг чинь унзад, гэсгүй нь байсан. Том лам нь бас гэсгүй ч байсан. Бас Зундуй гэдэг чинь унзад байсан. Хүрээний Намдолин аймагт унзад байсан хүн. Хийдийн анхны үндэслэгч нь Жамъян аграмба гэдэг хүн байсан. Дараа нь Дорж аграмба гэж байсан. Сандаг хамба гэж байсан. Жамъян хамбын дараагаар. Барианы түрүүхэнд мундаг хүн байсан гэсэн.

Гичгэний хийд хулгай дээрмийг аргалдаг айхтар сахиустай газар байсан. Хулгай дарна гэсэн тангарагтай. Тэгээд тийм сахиустай тийм газар байсан гэж ярьдаг.

- Олон дуган байсан уу?

Мэдэхгүй ээ дуганыг бол би мэдэхгүй. Тийм олон байгаагүй байх. Би очиж байгаагүй. Сүүлд л байхгүй болсон хойно нь суурин дээр нь очсон.

-Баатарын дацангаас тасарсан хэсэг сүүлд байгуулагдсан болж таарах нь ээ?

Тийм л болох гээд байна.

-Багацаагаар хэдэн оны үед?

Аа тэр бас л дээгүүр юм байлгүй дээ. Гичгэнэд нэг их айхтар их дуугардаг унзад байсан юм гэнэ билээ. Гичгэнэ их түүхтэй. Нэг үзмэрч хүн байсан юм гэнэ билээ. Тэр нь одоо 1800-аад оны эхээр байсан юм шиг байгаа юм. Гүржсоном гэж. Хараад л мэддэг, хэлдэг байсан гэдэг. Үзмэрч, зурхайч хүн байсан юм гэнэ лээ. Сургууль, эмнэлэг байгуулж олон хүн болно цаг ямар болох зэргийг бүгдийг нь хэлдэг хүн үнэмшмээргүй хүн байсан. Тэгээд тэр хүн нэг тогооны хүнтэй байж. Түүнийг байхгүй байхад нь нэг хүн ирээд явж л дээ. Цагаан морьтой явуулын хүн байж. Тэгээд ирээд ямар хүн ирэв гэтэл цагаан морьтой хүн л гэж. Тэр хүлэг унаж яваа хүн байна. Тэр морийг олж авалгүй бол болохгүй гээд хойноос нь явуулсан. Нөгөө явуулын хүн зүүн хойшоо явж байгаад энэ Мөрөн, Саригийн энд морио нэг айлд өгчихсөн юм гэнэ. Тэгээд тэр айл их хурдтай болсон гэж ярьдаг юм. Хүлэг, хүлгийн тоос гарлаа гэж хэлсэн юм гэнэ билээ. Ижилгүй хүн байсан юм гэнэ билээ. Бас нэг өөр домог бий. Нэг ядуу хоосон хүний хүү байжээ. Лам. Уншлага ном сайтай байсан ч хүрээнд очиж ном үзэх гээд чаддаггүй байсан байж. Хүрээ орох чадалгүй байж. Тэгсэн хүн нэг морь өгсөн юм гэнэ лээ. Адуутай хүн байж. Догшин морь байсан байна. Үүнийг унаж очоод хүрээ ороод зардалдаа хэрэглээрэй гээд өгсөн гэнэ. Тогооны хүн нь догшин морь өгч хүний хүүхэд сүйд хийлээ гэхэд зүгээр гэжээ. Тэгсэн нөгөө морь нь номхроод л зүгээр яваад өгчээ. Тэгээд тэр хүн хүрээ орж лам болсон юм гэнэ билээ. Хүрээнд сүүгаад учиргүй сайн нэртэй лам болж гэнэ. Шахмалаар учиргүй их дуугардаг юм гэнэ. Тэгсэн хүрээний Цогчэн унзад очоод тушаачихаж. Өмсөх

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гутал ч байхгүй юу ч байхгүй хүн чинь баруун хойшоо гараад өгч гэнэ. Явж явж нэг ханан хадны тэнд хонохоор болж гэнэ. Тэгсэн чоно замгүй их гэнэ. Ойрхон ирээд улиад байжээ. Нөгөө лам шахмал хоолойгоороо орилоход чононууд алга болсон байна. Өглөө босоод хартал чононууд хоолойноос нь сүрдээд баахан хар чацга гоожуулаад алга болсон байсан гэж ярьдаг юм билээ. Тэгээд явж байгаад нэг айлд хонь хариулжээ. Баруун аймагт Архангай орчмоор нэг баян айлын хонь хариулжээ. Ном үзье гэхээр өмсөх хувцас ч байхгүй байв. 2,3 жил тэр айлд хонь хариулжээ. Айл нь сайн айл байж өнөөхийг чинь хуралд хуруулахаар болжээ. Өвлийн Цэдэрт. Нөгөө лам андуураад нөгөө дуугаа гаргачихжээ. Өнөөх лам нар нь ухаан алдчихаж гэнэ. Хачин дуугардаг юм. Эхэлж хэлэхгүй ингэж сүйд хийх гэж гэхэд үнэн байдлаа хэлж гэнэ. Тэгээд Хүрээнд очиж их унзад болсон юм гэдэг. Тэгээд тэндээ хааяа нэг хурдаг байсан гэж хүмүүс ярьдаг юм.

-Хэн гэдэг хүн байсан бэ?

Хагархай Дайчин гэдэг хүн байсан. Тэгээд унзад болсон юм гэнэ билээ. Тэгээд Гичгэнэ дээр ирж хааяа нэг хурдаг байсан.5, 6км-ийн цаанаас дуу нь дуулддаг тийм хүн байсан юм гэнэ лээ. Лувсанжав гэж нэг настай лам байсан. Тэр л бидэнд үүнийг ярьж өгсөн.

-Гичгэний хийдийг хэдэн онд буулгасан юм бол?

1938 оны өвлөөс л эхэлсэн. Сайн мэдэхгүй байна. Өмнө нь бол буулгаагүй. Бүгдээрээ л байж байсан. Шарын шашны хийд байсан.

-Цэнхэрмандалын Согтуугийн хурал гэж байгаа. Тэр ямар учиртай хурал байсан юм бол?

Шарын шашны л ухаантай юм байсан юм шиг байна лээ. Архи л уучихдаг юм гэнэ лээ.

-Энэ Согтуугийн хурал харин их дуулдаг байгаагүй хурал юм шиг байгаа юм?

Харин тийм. Хаашаа юм бэ дээ. Ямар ч байсан манайхны сайн лам нар тэрүүгээр очиж хурдаг байсан, лам нар нь согтчихдог байсан л гэсэн.

Манайхны нэг сайн унзад өвгөн байсан юм. Тэр очиж хураад согтчихдог байсан. Орой болохоор л архи уугаад согтчихдог гэнэ.

-Тэр улирлын шинжтэй хурал байсан байхаа?

Мэдэхгүй. Дэлгэр цагаар л хурдаг байсан байх. Лам нар энэ хавиар тойроод хурдаг байсан байх.

-Хамбын хурлын талаар?

Мэргэн хамбын отог гэж байсан. Хошуу нутгаараа л шавь нь байсан.

-Тэр хүний байгуулсан хийд үү, Уртын шүтээн?

Тийм байхаа. 1800-аад оны үед л амьдарч байсан хүн байх. Хөлний өсгий нь холгоод таалал болсон гэж ярьдаг. Учиргүй л айхтар лам байсан гэсэн.

-Мэргэн хамбын хурал дээр хэр олон лам хурж байсан бол?

Барагтай олон лам хурдаггүй байсан.

-Энэ хавьд Пунцагтэгчилэнгээс илүү том хурал байсан үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энүүхэнд энэнээс илүү юм байгаагүй байгаа. Хутагтын хүрээ бол өөр. Бусад нь энийг гүйцэх газар байгаагүй байгаа. Дөрвөн газар зэрэг хурдаг байсан. Дайчид хурах гэж байсан.Одоо байдаг юм болов уу? Тэр хурал ламынхаа шарилыг шавардаад давслаад хатаачихдаг юм гэсэн. Жамъян аграмба гэдгийг тэгсэн болтой байсан гэж ярьдаг юм. Хааяа нэг дайчид хурна. Намайг байхад зүгээр хурал хураад тахилчтай, зул хүж өргөдөг тийм л газар байсан.

-Өөр Мэргэн хамбын хурлын тухай таны мэдэх юм юу байна?

Их сайхан хурал номтой байсан гэдэг.